

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Үлийн цагаан оготной микробиологийн аргаар тэмцэх ажилд шаардагдах микробиологийн бэлдмэлийн техникийн тодорхойлолтын шаардлагын талаар:**

1. Энэхүү тендерээр нийлүүлэх микробиологийн бэлдмэл нь монгол орны нөхцөлд үлийн цагаан оготной тэмцэх ажлын зориулалтаар туршиж, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн, Монгол улсад 2020 онд хөдөө аж ахуйд ашиглахыг зөвшөөрсөн биобэлдмэлүүдийн жагсаалтын “родентицид”-ийн хэсэгт орсон ургамал хамгааллын бодис байна.
2. Тендерт оролцогч нь дараах баримт бичгийг бүрдүүлэн ирүүлнэ. Үүнд:
  - 2.1. Санал болгож буй родентицидийн үйлдвэрлэгчийн тухай танилцуулгыг ирүүлнэ.
  - 2.2. Санал болгож буй родентицидийн танилцуулга.

(Танилцуулганд бэлдмэлийн худалдааны нэр, хэлбэр, хүчинтэй байх хугацаа, үйлчлэх бодисын нэр, эзлэх хувь, томьёо, үхлийн тун /LD<sub>50</sub>/, өнгө, байгаль дээр задрах хугацаа, нэг га-д зарцуулах хэмжээ, савлалт, хадгалалт, тээвэрлэлт, тухайн бодис, түүний хольц, хаягдлыг устгах аргачлал, хүний эрүүл мэнд, байгаль орчинд хэрхэн нөлөөлөх талаар, мал, амьтан хордохоос урьдчилан сэргийлэх, хордсон тохиолдолд мөрдөх аюулгүй ажиллагааны талаар орсон байх шаардлагатай). Энэ нь үйлдвэрлэгчээс хэвлүүлж гаргасан заавар, танилцуулга, каталог хэлбэрээр байна.
  - 2.3. Микробиологийн бэлдмэлийн гарал үүслийг тодорхойлох үйлдвэрлэгчийн гэрчилгээ, түүнтэй адилтгах баримт бичиг.
  - 2.4. Тухайн микробиологийн бэлдмэлийг үйлдвэрлэх эрхийн бичиг, түүнтэй адилтгах баримт бичиг.
  - 2.5. Нийлүүлэхээр санал болгож буй микробиологийн бэлдмэлийн талаарх тухайн орны стандарт, чанарын гэрчилгээ, түүнтэй адилтгах баримт бичиг.
  - 2.6. Тухайн микробиологийн бэлдмэлийн дотоодын эсвэл олон улсын бүртгэлийн дугаар.
3. Нийлүүлэх барааны техникийн тодорхойлолтын холбогдох үзүүлэлтийг үнэн болохыг гэрчилсэн баримт бичгийг монгол хэл дээр орчуулан, орчуулгын товчоогоор баталгаажуулан ирүүлнэ.
4. Нийлүүлэгч нь ургамал хамгаалах бодис импортлох, борлуулах тусгай зөвшөөрөлтэй байна.

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ, ШААРДЛАГА

**Нэр:** Үлийн цагаан оготной тэмцэх ажилд шаардагдах микробиологийн бэлдмэл нийлүүлэх.

**Төсөвт өртөг:** 46,000,000 /дөчин зургаан сая төгрөг/

№	Үзүүлэлт	Нийлүүлэгчийн тодорхойлолт
1	<p style="text-align: center;"><b>Родентицидийн ерөнхий үзүүлэлтүүд</b></p> <p>1.1 Родентицидийн нэр: “Бактерийн бэлдмэл” эсхүл түүнтэй дүйцэх “Үлийн цагаан оготной микробиологийн аргаар тэмцэх зориулалтаар туршиж, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн ургамал хамгааллын бодис байна”</p> <p>1.2 Үйлдвэрлэгчийн нэр хаяг:</p> <p>1.3 Нийлүүлэх микробиологийн бэлдмэл нь олон улсын болон Монгол Улсын холбогдох стандарт шаардлага хангасан байна.</p> <p>1.4 Хоргүй чанар /бэлдмэлээс малд идүүлэхэд 14 хоногт өвчлөхгүй байх/</p> <p>1.5 Родентицидийн хэлбэр нь: хатуу өгөөш байна.</p> <p>1.6 Үйлдвэрлэсэн огноо: 2019 онд үйлдвэрлэсэн байна.</p> <p>1.7 Родентицидийн хүчинтэй байх хугацаа: 2 жилээс доошгүй байна.</p> <p>1.8 Олон улсын бүртгэлийн дугаар:</p> <p>1.9 Тогтвортой байдал: +15 – (-15) хэмд 30 хоногоос доошгүй хугацаанд идэвхээ хадгалах.</p>	
2	<p style="text-align: center;"><b>Родентицидийн физик, химийн шинж</b></p> <p>2.1 Үйлчлэх бодисын нэр, эзлэх хувь:</p> <p>2.2 Родентицидийн томьёо:</p> <p>2.3 Үхлийн тун /LD<sub>50</sub>/:</p> <p>2.4 Гадаад байдал: өнгө, үнэр гэх мэт:</p>	
3	<p style="text-align: center;"><b>Родентицидийн үйлчилгээний механизм</b></p> <p>3.1 Родентицид нь үлийн цагаан оготны аль эд эрхтэнд үйлчилдэг талаар:</p> <p>3.3 Родентицид хэрэглэсний дараах үхлийн үр дүн:</p> <p>3.4 Родентицидийн хэрэглэсний дараа байгаль дээр задрах хугацаа:</p>	
4	<p style="text-align: center;"><b>Родентицидийн савлалт, хадгалалт, хэрэглээ</b></p> <p>4.1 Савлагаа: 35 кг-аас илүүгүй хэмжээтэй байна. Хадгалах, тээвэрлэхэд цоорохгүй, бат бэх савлагаатай байна.</p>	
5	<p style="text-align: center;"><b>Родентицидийн үнэ</b></p> <p>5.1 Нэгжийн үнэ: /кг/төг/</p>	

**Жич:** Нийлүүлэгчийн санал болгож буй бодисын техникийн тодорхойлолтын үзүүлэлт бүрийг үнэн зөв гэдгийг нотлох зорилгоор үйлдвэрлэгчийн хэвлэж гаргасан каталог,

танилцуулга, зураг, туршилт, шинжилгээ, судалгааны дүн гэх мэтийг хавсаргаж ирүүлсэн байна.